



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА МИЕЭГОМБЫН
ЭНХБОЛД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Дуламдоржийн ТОГТОХСҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон.
Утас: 26-13-35, Факс: 32-70-16
E-mail: tcgtokhsuren@parliament.mn
http://www.parliament.mn

2018.05.15 № 5662

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-д заасан бүрэн эрхийнхээ дагуу УИХ-ын гишүүд бид Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Татварын ерөнхий хууль, Бүртгэлийн ерөнхий хууль, Статистикийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 30 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.ТОГТОХСҮРЭН
Н.АМАРЗАЯА
Ё.БААТАРБИЛЭГ
Ж.БАТЗАНДАН
Д.ТАНБОЛД
Ц.МӨНХ-ОРГИЛ
Х.НЯМБААТАР



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН
 ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН
 БИЧГИЙН ДАРГА Ц.ЦОЛМОН
 ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
 Дуламдоржийн ТОГТОХСҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
 Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
 Утас: 26-13-35, Факс: 32-70-16
 E-mail: togtochsuren@parliament.mn
 http://www.parliament.mn

2018.05.11 № 5508

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
 мэдүүлэх хугацааг товлох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-д заасан бүрэн эрхийнхээ дагуу УИХ-ын гишүүд бид Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Татварын ерөнхий хууль, Бүртгэлийн ерөнхий хууль, Статистикийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт 30 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
 ГИШҮҮН



Д.ТОГТОХСҮРЭН

Н.АМАРЗАЯА

Ё.БААТАРБИЛЭГ

Ж.БАТЗАНДАН

Д.ГАНБОЛД

Ц.МӨНХ-ОРГИЛ

Х.НЯМБААТАР



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018.05.04 дугаар
сарын 04-ны өдөр

Дугаар ХЭГ/959

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ТОГТОХСҮРЭН ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Г.ЗАНДАНШАТАР

004352

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

“ХИ.ХЭЛЭЛЦСЭН нь:

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн санаачлан боловсруулсан Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн санаачлан боловсруулсан Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцээд дараах саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3.1.1-д улсын бүртгэлийн үйл ажиллагаанд “нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх” зарчмыг баримтлахаар, мөн хуулийн 7.2-т “Улсын бүртгэлийн байгууллага нь нэгдмэл тогтолцоо, төвлөрсөн удирдлагатай байна” гэж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1-д “Мэргэжлийн хяналтын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд түүнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж, мөн хуулийн 9.2-т “Мэргэжлийн хяналтын байгууллага нь мэргэжлийн хяналтын төв байгууллага, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, хилийн мэргэжлийн хяналтын алба, сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ” гэж тус тус хуульчилсантай Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нийцэхгүй байх тул дэмжих боломжгүй байна.

Харин Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг зарчмын хувьд дэмжиж байна.” гэжээ.

Хурлын гишүүн
Д.Тогтохсүрэнгийн
саналыг
хууль санаачлагчид
уламжлахаар
тогтов.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.6} дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 27^{1.6.11} дэх заалт нэмсүгэй:

“27^{1.6.11}.Сумын татварын улсын байцаагчийг аймгийн татварын хэлтсийн даргатай зөвшилцөн сумын Засаг дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.4} дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“27^{1.4}.Аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн татварын хэлтсийн даргыг нийслэлийн татварын газрын даргатай зөвшилцөж дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан ажлын тайлан

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад тухайлбал Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Татварын ерөнхий хууль, Бүртгэлийн ерөнхий хууль, Статистикийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-д \ Цаашид “аргачлал” гэх\ заасны дагуу хийв.

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйлд “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж, Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ.” гэж тус тус заан орон нутгийн удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон болно. Шинэ Үндсэн хуулийн дагуу 1992 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 1994 онд Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг Улсын Их Хурлаас баталж захиргааны зарим эрх мэдлийг аймаг, нийслэл, сумдад шилжүүлэн орон нутгийн захиргааны эрх мэдлийг нэмэгдүүлсэн билээ.

Судалгаанаас үзэхэд 1992 – 2002 оны хооронд төрөөс төвлөрлийг сааруулах бодлогыг идэвхтэй дэмжиж, үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд төвлөрөл харьцангуй саарч орон нутгийн эрх мэдэл нэмэгдсэн боловч 2003 оноос Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр эрх мэдлийг эргэн төвлөрүүлэх үйл явц эхэлсэн байна.

2005 оны 11 дүгээр сард Улсын Их Хурлаас орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах асуудлыг судлан дүгнэлт гаргах, санал боловсруулах үүрэг бүхий Түр хороог байгуулсан бөгөөд Түр хорооноос “орон нутгийн зарим байгууллагуудын боловсон хүчний томилгоо босоо тогтолцоотой байгааг өөрчлөх эсэх” гэсэн асуудлаар 800 хүнээс судалгаа авахад нийт судалгаанд оролцогчдын 83,9 хувь нь боловсон хүчний асуудлыг тухайн шатны Засаг дарга дээд шатны байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилж чөлөөлдөг байх нь зүйтэй гэсэн хариулт өгсөн талаар тухайн үед байгуулагдсан Улсын Их Хуралд танилцуулагдаж байсан байна.

Өнөөдөр орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан шатанд үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагын хүний нөөц, түүний чадавхийг бэхжүүлэх, чиг үүрэг, эрх мэдлийг оновчтой хуваарилах, шилжүүлэх ажлыг дэс дараатай, тогтвортой, тодорхой үе шаттай хийж төвлөрлийг сааруулах үйл явцыг эрчимжүүлэх шаардлага байсаар байна. Энэ талаар бодлогын баримт бичгүүдэд ч тусгагдсан. Тухайлбал: Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой

хөгжлийн үзэл баримтлал-2030"-д тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монгол Улс 2030 онд "хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна." гэсэн зорилт дэвшүүлж, төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах, хууль дээдлэх зарчмыг чанд мөрдөх, удирдлагын ил тод байдлыг хангах, төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах, төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах нь тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим гэж тодорхойлсон.

Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн "Тав. Засаглалын бодлого" хэсэгт "5.1.21.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно." гэж заасан.

Бодит байдал дээр төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд хийгдсэн хуулийн өөрчлөлтүүд богино хугацаанд өөрчлөгдөн өмнө нь Улсын Их Хурлаас баримтлан хэрэгжүүлж байсан төвлөрлийг сааруулах бодлого, арга хэмжээний хүч суларч удирдлагын босоо тогтолцоонд эргэн шилжих, төвлөрүүлэх үйл явц хүчтэй илрэх чиг хандлагатай байна. Энд төсөв санхүү, хүний нөөц, бүтэц зохион байгуулалт гээд олон шалтгаан байгаа хэдий ч төрийн зүгээс урт хугацааны тавьсан бодлого, зорилгоо тогтвортой мөрдөж хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл чухал байна.

Орон нутагт мэргэжлийн байгууллагын удирлага, ажилтныг томилохдоо дээд шатны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга нь томилж байх зарчмыг хэрэгжүүлснээр өмнө нь Улсын Их Хурлаас төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үргэлжилэл болох бөгөөд орон нутгийн мэргэжлийн байгууллагын удирдлага, ажилтныг томилохтой холбогдсон зохицуулалт нэг ижил зарчмаар мөрдөгдөх болно. Тухайн шатны Засаг даргад дээд шатны байгууллагын даргатай зөвшилцөн Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж байх эрхийг хуульчлан олгох нь зөв байна.

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилго, зохицуулалтын хувилбар

Зорилго:

Орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан шатанд үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагын хүний нөөц, түүний чадавхийг бэхжүүлэх үүднээс тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагын удирдлага, ажилтныг Төрийн албаны тхай хуульд заасан шаардлагыг хангасан иргэнээс сонгон шалгаруулж томилон үр дүнг нь дүгнэдэг байх.

Асуудлыг зохицуулахад дараахь хувилбаруудыг харьцуулан судаллаа.
Үүнд:

1. "тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
2. хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

"Тэг" хувилбар

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан өнөөгийн хуулийн зохицуулалтыг хэвээр хадгалах нь асуудлыг шийдвэрлэх зорилгыг хангаж чадахгүй бөгөөд орон нутгийн мэргэжлийн байгууллагын удирдлага, ажилтныг томилохтой холбогдсон зохицуулалт нэг ижил зарчмаар мөрдөгдөхгүй болно.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар

Тухайн шатны Засаг дарга нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагын удирдлага, ажилтныг Төрийн албаны тхай хуульд заасан шаардлагыг хангасан иргэнээс сонгон шалгаруулж томилох нь ижил төстэй харилцааг адил зарчмаар зохицуулах боломжийг бүрдүүлж байна.

ooOOoo

**Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог
зохицуулсан зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ**

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад тухайлбал Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Татварын ерөнхий хууль, Бүртгэлийн ерөнхий хууль, Статистикийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-д \Цаашид "аргачлал" гэх\ заасны дагуу хийв.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг хийх доорх шалгуур үзүүлэлтийг дээр дурьдсан аргачлалын дагуу сонголоо. Үүнд:

1. зорилгод хүрэх байдал;
2. практикт хэрэгжих боломж.

Зорилгод хүрэх байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалт нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж түүнд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах үндэслэл, практик шаардлага, төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ зэргийг хуулийн төслийн зорилт, зохицуулалттай харьцуулан үзлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд орон нутгийн түвшинд төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан шатанд үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагын хүний нөөц, түүний чадавхийг бэхжүүлэх, чиг үүрэг, эрх мэдлийг оновчтой хуваарилах, шилжүүлэх ажлыг дэс дараатай, тогтвортой, тодорхой үе шаттай хийж төвлөрлийг сааруулах үйл явцыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага байгаа бөгөөд төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд өмнө авч байсан арга хэмжээний үргэлжлэл болгон орон нутагт мэргэжлийн байгууллагын удирлагыг томилохдоо дээд шатны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга нь Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулан томилж үр дүнгийн гэрээ байгуулан дүгнэдэг байх зорилгыг дэвшүүлжээ.

Аргачлалын дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхээр сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэв.

**"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн
үнэлгээ**

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон ба хуулийн төслүүдийн зохицуулалтыг харьцуулан авч үзлээ.

1) Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нийгмийн даатгалын тухай хуулийн “Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага” гэсэн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг “аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын газар, хэлтсийн даргы гнийгмийн даатгалын төв байгууллагын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн даргы гнийслэлийн нийгмийн даатгалын газрын даргатай зөвшилцөж дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.” гэж өөрчлөх гэсэн заалтыг;

2\Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нийгмийн халамжийн тухай хуулийн “Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, хяналт” гэсэн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг “аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.” гэж өөрчлөх гэсэн заалтыг;

3\Татварын ерөнхий хууль өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Татварын ерөнхий хуулийн “Татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх” гэсэн 27¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг “Аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга, дүүргийн татварын хэлтсийн даргыг нийслэлийн татварын газрын даргатай зөвшилцөж дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.” гэж өөрчлөх, 27¹ дүгээр зүйлийн 27¹.6 дахь хэсэгт “Сумын татварын улсын байцаагчийг аймгийн татварын хэлтсийн даргатай зөвшилцөн сумын Засаг дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.” гэсэн 27¹.6.11 дэх заалт нэмэх гэсэн заалтыг;

4\Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн “ Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, түүний нийтлэг бүрэн эрх” гэсэн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг “Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын даргыг мэргэжлийн хяналтын төв байгууллагын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.” гэж өөрчлөх гэсэн заалтыг;

5\Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн “Ус цагуур, орчны хяналт шинжилгээний төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх” гэсэн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг “Ус, цагуур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжийн албан хаагчийг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг бүхий байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.” гэж өөрчлөх гэсэн заалтыг;

6|Бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Бүртгэлийн ерөнхий хуулийн “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагынчигүүрэг” гэсэн 8 дугаар зүйлд “Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар, нэгжийн дарга, улсын бүртгэгчийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.” гэсэн 8.2 дахь хэсэг нэмэх. Мөн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг хүчингүй болгох гэсэн заалтыг.

7|Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн даргыг Үндэсний статистикийн хорооны даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.” гэсэн 7 дахь хэсэг нэмэх. Мөн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг хүчингүй болгох гэсэн заалтыг.

8|Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө. Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан газар, хэлтсийн даргыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.” гэсэн 18.3, 18.4 дэх хэсэг нэмэх гэсэн заалтуудыг тус тус сонгосон болно.

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан дээрх хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавинесдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах гэсэн зарчмыг, түүнчлэн Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тодорхойлсон “төрийн бодлогын залгамж чанар, төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах, төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авлигыг арилгах нь тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим” гэснийг, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллаганы хөтөлбөр”-т дурьдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.” гэсэн заалтыг бодитойгоор хэрэгжүүлэхэд алхам болгож, өмнө нь Улсын Их Хурлаас төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үргэлжилэл болгон орон нутгийн мэргэжлийн

байгууллагын удирдлагыг томилохтой холбогдсон зохицуулалт нэг ижил зарчмаар мөрдөгдөх байхаар хуулийн төслийг боловсруулсан нь хуулийн зорилгод хүрэх боломжтой гэж үзэж байна. Энэ нь төвлөрлийг сааруулах үйл явцын дараагийн шатны арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чухал суурь болж өгнө.

"Практикт хэрэгжих боломж" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

2005 оны 11 дүгээр сард Улсын Их Хурлаас орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах асуудлыг судлан дүгнэлт гаргах, санал боловсруулах үүрэг бүхий Түр хороог байгуулсан. Түр хороо тухайн үед хийсэн судалгаа, орон нутгаас ирүүлсэн санал зэрэг дээр үндэслэн орон нутагт удирдлагын босоо тогтолцоо давамгайлж, эрх мэдлийн төвлөрлийг бий болгосон нь орон нутгийн бие даасан байдлыг алдагдуулсан гэж дүгнэн эхний ээлжинд орон нутгийн удирдлагад боловсон хүчнийг томилж, чөлөөлөх эрхийг шилжүүлэх хэрэгтэй гэж үзээд холбогдох хуулинд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсан байна. 2006 оны Улсын Их Хурлын хаврын чуулганаар эдгээр хуулийн төслүүдийг хэлэлцэх үед орон нутгийн мэргэжлийн байгууллагын удирдлагыг дээд шатны байгууллагын даргатай зөвшилцөн мэргэжлийн бөгөөд ажилласан жилийн шалгуур хангасан хүнийг Засаг дарга томилдог зарчимыг дэмжих эсэх асуудлаар санал хураахад гишүүдийн олонхийн саналаар энэ зарчмыг дэмжсэн тул 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 15 хуульд өөрчлөлт оруулсан хуулийг баталжээ. Энэ зарчим Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тухай, Архивын тухай, Соёлын тухай, Эрүүл мэндийн тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай зэрэг 19\ хуулинд тогтвортой мөрдөгдөж байна. Хуулийн төслийн зохицуулалт практикт туршигдсан гэж үзлээ.

Дүгнэлт

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Татварын ерөнхий хууль, Бүртгэлийн ерөнхий хууль, Статистикийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих боломжтой гэж дүгнэж байна.

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалыг ашиглав.

Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Татварын ерөнхий хууль, Бүртгэлийн ерөнхий хууль, Статистикийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд батлагдсанаар тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохдоо нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа заалтаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд шинээр чиг үүрэг бий болгосон эсэхийг үндэслэсэн болно.

Нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хуулийн төслүүдээр зөвхөн орон нутгийн мэргэжлийн байгууллагын удирдлагыг дээд шатны байгууллагын даргатай зөвшилцөн мэргэжлийн болон Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг Засаг дарга томилох, чөлөөлөхтэй холбогдсон заалтыг тухайн Засаг даргын бүрэн эрхэд оруулж байгаа бөгөөд энэхүү өөрчлөлтөөс хамааран төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд шинээр чиг үүрэг бий болгоогүй тул нэмэлт зардал гаргахгүйгэр хэрэгжих боломжтой. Иймд хуулийн төсөлтэй холбоотойгоор улсын төсвөөс нэмэгдэл хөрөнгө шаардагдахгүй гэж үзэж байна.

ooOoo

Цахим хэлэлцүүлэгт оролцсон иргэдээс ирүүлсэн саналууд нэгтгэсэн товъёог

№	Санал гаргасан	Өгсөн санал	Төсөлд тусгасан эсэх
1	Санжаажамц Батхүү	Төслийг дэмжихгүй	Тодорхой саналгүй тул аваагүй
2	Базарсад Уранчимэг	Төслийг дэмжиж байна	Төсөлд тусгагдсан
3	Энхээ Жигжиддорж	Төслийг дэмжиж байна	Төсөлд тусгагдсан
4	Цээгий Гомбосүрэн	Төслийг дэмжихгүй	Тодорхой саналгүй тул аваагүй
5	Дэмбэрэлжав Нарангэрэл	<p>Төслийг дэмжиж байна.</p> <p>Удирдлагын босоо тогтолцоонд хуулийн нэмэлт өөрчлөлт оруулсанаар орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч орон нутгийн хөгжил, орон нутгийн иргэдийн ашиг сонирхолд түлхүү анхаарах боломж бүрдэх юм. мөн хариуцлагын асуудал бодитой болно.</p> <p>Орон нутаг дахь төрийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагыг аймгийн Засаг дарга томилж чөлөөлдөг байх.</p>	Төсөлд тусгагдсан
6	Валя Цэнгэлмаа Дорнод аймаг Төрийн аудитын газар	<p>Босоо тогтолцоотой газруудын удирдлагын томилгоонд тухайн орон нутгийн Засаг даргын оролцоог нэмэгдүүлж байгааг дэмжиж байна.</p> <p>Энэ нь орон нутаг дахь Засаглалын чадавхийг нэмэгдүүлж ажлын уялдаа холбоо, сахилга хариуцлагыг сайжруулна.</p>	Төсөлд тусгагдсан
7	Тыгад Аршагүл Баян-Өлгий аймгийн ИТХ	<p>Төслийг дэмжиж байна.</p> <p>Удирдлагын босоо тогтолцоонд хуулийн нэмэлт өөрчлөлт оруулсанаар орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч орон нутгийн хөгжил, орон нутгийн иргэдийн ашиг сонирхолд түлхүү анхаарах боломж бүрдэх, хариуцлагын асуудал бодитой болох юм.</p>	Төсөлд тусгагдсан
8	Энхцэцэг Дашхүү Увс аймгийн ИТХ	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
9	Цогоо Азжаргал	Статистикийн хэлтсийн дарга нарыг аймаг, дүүргийн засаг дарга нартай зөвшилцөж байж томилохтой санал нийлэхгүй байна. Учир нь статистикийн байгууллага нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг байхаар холбогдох хууль тогтоомжоор зохицуулагдсан. Иймд	Төсөлд тусгаагүй

		аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлж байх нь зөв юм.	
10	Эрдэнэцогт Анхцэцэг	Орон нутгийн статистикийн хэлтсийн даргыг Үндэсний статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагын дагуу сонгон шалгаруулж томилж, чөлөөлж байх нь зөв.	Төсөлд тусгаагүй
11	Ундрах Оёо	Статистикийн хэлтсийн дарга нарыг аймаг, дүүргийн засаг дарга нартай зөвшилцөж байж томилохтой санал нийлэхгүй байна. Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлж байх нь зөв.	Төсөлд тусгаагүй
12	Цэвэгсүрэн Алтаа	Төрийн албаны хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулж ҮСХ-ны дарга томилж, чөлөөлж байх нь зөв гэж бодож байна.	Төсөлд тусгаагүй
13	Цэндсүрэн Хад	Статистикийн хэлтсийн дарга нарыг аймаг, дүүргийн засаг дарга нартай зөвшилцөж байж томилохтой санал нийлэхгүй байна. Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлж байх нь зөв.	Төсөлд тусгаагүй
14	Бямбажав Ганболд Ховд аймаг ЗД-ын Ажлын алба	Төслийг бүрэн дэмжиж байна. Санал: Нэг. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтын дагуу аймаг, нийслэлийн стандартчиллын байгууллагын даргыг стандартчиллын төв байгууллагын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлдөг. Харин 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөх Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтаар аймаг, нийслэлийн стандартчилал, техникийн зохицуулалтын байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлөхөөр болсон. Иймээс хуулийн дээрх заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, аймаг, нийслэлийн стандартчиллын байгууллагын даргыг стандартчиллын төв байгууллагын	Төсөлд тусгагдсан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Онцгой байдал, Цагдаагийн байгууллагын хуулиудад өөрчлөлт оруулах шаардлагагүй.

	<p>даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлдөг болох.</p> <p>Хоёр. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 10 дахь заалтаар зохих шатны Засаг даргатай зөвшилцөн тухайн дархан цаазат газар, байгалийн цогцолборт газарт хамгаалалтын захиргаа байгуулах асуудлыг шийдвэрлэж, даргыг нь байгаль орчны мэргэжилтэй, тухайн салбарт 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилохыг Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулсан. Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтаар сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөхийг усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулсан. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын болон сав газрын захиргааны даргыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн аймгийн Засаг дарга томилж, чөлөөлдөг байхаар дээрх хуулиудад өөрчлөлт оруулах.</p> <p>Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба-Хорих ангийн дарга, Шүүхийн шинжилгээний албаны дарга, Нисэх буудлын дарга, Гадаадын иргэн харьяатын газрын салбарын дарга, Онцгой байдлын газрын дарга нарыг томилж, чөлөөлөхөд аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцдөг байх нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хуулиудад оруулах.</p>	
Төсөлд тусгаагүй	<p>15 Гэрэл</p> <p>Статистикийн хэлтсийн дарга нарыг аймаг, дүүргийн засаг дарга нартай зөвшилцөж байж томилохтой санал нийлэхгүй байна.</p> <p>Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлж байх нь зөв.</p>	
Төсөлд тусгаагүй	<p>16 Сара Саранчимэг</p> <p>15 дугаар зүйл. Үндэсний статистикийн хорооны даргын бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх баталгаа зүйл. Албан ёсны статистикийн бие даасан, хараат бус, ил тод байдлыг хангах, улс, орон нутгийн хэмжээнд албан ёсны статистикийн үйл ажиллагааг төвлөрүүлэн эрхэлдэг байх үүднээс тус хуулийн төсөлд "аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг ҮСХ-ны дарга "Төрийн албаны тухай" хуульд заасан шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, томилж, чөлөөлнө" гэж оруулах, эсхүл одоо мөрдөж байгаа хуулийн 15-р зүйлийн 2-дах хэсгийг " аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх" гэж хэвээр үлдэх нь зүйтэй.</p>	

17	Тунгалаг Эрдэнэбат	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.	Төсөлд тусгаагүй
18	Энхтүвшин Энхтунгалаг	Үндэсний Статистикийн Хороон дарга аймаг, орон нутгийн статистикийн газар, хэлтсийн даргыг төрийн албаны тухай хуулийн дагуу тогтоосон шалгуурыг хангасан хүнийг сонгон шалгаруулж, томилж, чөлөөлөх нь зөв.	Төсөлд тусгаагүй
19	Авирмэд Батхишиг	аймаг дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс газрын даргыг Үндэсний статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилох нь зөв.	Төсөлд тусгаагүй
20	Лхагва Ундрал	Үндэсний Статистикийн Хороо нь хараат бус, бие даасан байхаар зохион байгуулагдах ёстой гэж үзэн 2016 онд засгийн газрын харьяаллаас эргүүлэн Улсын Их Хурлын харьяалалд оруулж байсан, харин уг хуулийн төсөлд дахин дээрх зарчимд харшлахаар нэмэлт өөрчлөлтийг оруулж ирж байгаатай санал нийлэхгүй байна. Үндэсний Статистикийн Хорооны дарга нь аймаг, орон нутгийн статистикийн газар, хэлтсийн даргыг төрийн алба, мэргэжлийн түвшний тогтоогдсон шалгуурыг хангасан хүнийг сонгон томилж, чөлөөлөх нь зөв.	Төсөлд тусгаагүй
21	Базаррагчаа Сэрдагва	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.	Төсөлд тусгаагүй
22	Тойв Жигжидсүрэн	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.	Төсөлд тусгаагүй
23	Хорол Давгажав	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.	Төсөлд тусгаагүй
24	Мөөгий	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.	Төсөлд тусгаагүй
25	Я.Оюунзул Сүхбаатар аймаг ЗДТГ	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
26	Бальдар Чулуунаа	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний	Төсөлд тусгаагүй

		Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.		Төсөлд тусгаагүй
27	Самдан	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.		Төсөлд тусгаагүй
28	Энхболд	Нийслэл дүүргийн статистикийн газар хэлтсийн даргыг Үндэсний Статистикийн Хорооны дарга томилж байх нь зөв.		Төсөлд тусгаагүй
29	Эрдэнэ-Очир Мягаа	Статистикийн хэлтсийн дарга нарыг аймаг орон нутгийн засаг дарга нартай зөвшилцөж байж томилохтой санал нийлэхгүй байна. Бие даасан, хараат байх нь зүйтэй буюу ажлын байрны шаардлагыг хангасан мэргэжлийн удирдлагыг УСХ-н даргын тушаалаар томилох нь зүйтэй.		Төсөлд тусгаагүй
30	Базардаргиа Гэрэлмөнх	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх” нь зөв.		Төсөлд тусгаагүй
31	Хүнбиш Ганзориг	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.		Төсөлд тусгаагүй
32	Сара Сакуна	УСХ-ны дарга Төрийн албаны хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулж томилж, чөлөөлж байх нь зөв.		Төсөлд тусгаагүй
33	Дэмчиг Гансүх	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.		Төсөлд тусгаагүй
34	Баянчимэг Чилхаасүрэн	аймаг дүүрэг нийслэлийн Засаг даргатай заавал зөвшилцөх шаардлагагүй УСХ-ны дарга Төрийн албаны хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулж томилж, чөлөөлж байх нь зөв.		Төсөлд тусгаагүй
35	Сугир Бямбаа	аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын даргыг Үндэсний Статистикийн хорооны дарга Төрийн албаны тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилж, чөлөөлөх нь зөв.		Төсөлд тусгаагүй
36	Дугар Нямаа	Статистикийн тухай хуульд оруулж байгаа нэмэлт өөрчлөлтийг дэмжихгүй байна. Статистикийн хараат бус байдлыг зөрчиж байна. Хамгийн гол анхдагч мэдээллийг боловсруулдаг Нийслэлийн Статистикийн газар, аймгууд, дүүргүүдийн статистикийн хэлтсүүдийн удирдлагыг УСХ-ны		Төсөлд тусгаагүй

	даргын шийдвэрээр томилдог байх ёстой.		
37	Нацагдорж Энхтуяа	Төсөлд тусгаагүй	Төсөлд тусгаагүй
38	Амар Энхнаран Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
39	Жаргалсайхан Тамжид Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
40	Чулуунбат Нямсамбуу Нийслэлийн архивын газар	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
41	Таагал Одонтоого Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар	Саналгүй	Саналгүй
42	Пүрэвжав Оюунцэцэг	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
43	Баттогтох Энхзаяа БЗД-ийн ЗДТГ	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
44	Б.Билгүүн Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан
45	Дарьсүрэн Жаргалсайхан Дархан-Уул аймаг ЗДТГ	Төслийг дэмжиж байна.	Төсөлд тусгагдсан

000000